



МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороог шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалт, 9.8 дахь хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 1.5, 2.5, 2.7, яамны Хөдөлмөрийн дотоод журмын 2.19-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус яамны бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдсэнтэй холбогдуулан нийт албан хаагчдын дунд зохион байгуулсан санал асуулгын дүнгээр олонхын санал авч дэмжигдсэн доор дурдсан албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр Ёс зүйн дэд хороог 2026 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Гишүүд:

Д.Батбаяр
(Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга).

Б.Загарсүрэн
(Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч);

Л.Нямдорж
(Хууль, эрх зүй, хамтын ажиллагааны хэлтсийн дарга);

Б.Солонго
(Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын Салбарын хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах шинжээч);

Ш.Самданжамц
(Харилцаа холбоо, кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын

Сүлжээ, дэд бүтцийн зохицуулалт хариуцсан шинжээч).

2. Ёс зүйн дэд хорооны гишүүдийн олонхын саналаар дарга, нарийн бичгийн даргыг сонгож, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны гишүүдэд үүрэг болгосугай.

3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийн урамшуулал, чадавхжуулахтай холбогдох зардлыг жил бүр төсөв тусган бүрэн санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (О.Золзаяа)-д даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын “Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/126, “Ёс зүйн дэд хорооны гишүүнийг нөхөн сонгосныг баталгаажуулах тухай” 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/77 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.МЯГМАРНАРАН